



**АВСТРАЛИ УЛСЫН КҮЙСЛАНД МУЖИЙН
ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ**

Зөвшөөрөлгүй барилга байгууламж барих хэрэгт оногдуулах торгуулийн хэмжээ нь хууль бус үйлдлийн шинж чанарт тохирсон байх тухай

Марн э. Гинтер

[\[2022\] КМШ 26](#)

САНАМЖ: Энэхүү хураангуй нь гагцхүү олон нийтэд мэдээлэл болгох зорилготой бөгөөд хураангуй нь гадаадын хяналтын шатны шүүхийн шийдвэр болно.

Нөхцөл байдал

Яллах талаас Күйнслэнд мужийн Шүүхийн тухай хуулийн (1886) 222 дугаар зүйлд заасны дагуу хариуцагчид оногдуулсан торгууль нь түүний үйлдлийн шинж чанарт тохироогүй гэж үзэж дээд шатны шүүхэд ханджээ. Хариуцагч өөрийн өмчийн газар доторх усны суваг дээгүүр зөвшөөрөлгүй явган хүний гүүр барьсантай холбоотойгоор Кабультурийн Магистратын шүүхээс Хот төлөвлөлтийн тухай хуулийн (2016) 163 дугаар зүйлд заасныг зөрчиж 2 удаагийн үйлдлээр зөвшөөрөлгүй барилгажуулалт хийсэн хэргээр буруутгагдсан байна.

Күйнслэнд мужийн Загас агнуурын тухай хуулийн 76S, 76T хэсгүүдэд зааснаар тухайн хэрэгт оногдуулах торгуулийн дээд хэмжээ нь хариуцагчийн удаа дараагийн үйлдэлд тус бүр 2000 нэгж болон 3000 нэгжтэй тэнцүү хэмжээтэй байна.

Шүүхээс хариуцагчийн 2 удаагийн үйлдэлд нийтэд нь 7.500 долларын торгууль болон 99 долларын шүүхийн зардал, 250 долларын өмгөөлөгчийн зардлыг төлүүлэхээр шийдвэрлэжээ. Ингэхдээ Күйнслэнд мужийн Хот төлөвлөлтийн тухай хуулийн 176 дугаар зүйлд заасан тухайн газар нутагт нөхөн сэргээх ажиллагаа хийлгэх нэмэгдэл албадлагын арга хэмжээ хэрэглээгүй байна.

Үндсэн асуудал

Яллах талын зүгээс хяналтын шатны шүүхэд гаргасан үндэслэлдээ нэгдүгээрт, хариуцагчид торгох ял оногдуулахдаа Күйнслэнд мужийн Ял шийтгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.с заалтад зааснаар ял шийтгэлийн үндсэн зарчмуудын нэг болох “ерөнхий урьдчилан сэргийлэх” зарчмыг харгалзаж үзээгүй. Хоёрдугаарт, шүүх нь хариуцагчид тухайн газрыг өмнөх байсан байдалд нь оруулж нөхөн сэргээлт хийх албадлагын арга хэмжээ авч шийдвэрлээгүй нь хууль зөрчсөн гэж маргажээ.

Хариуцагч явган хүний гүүр барих зөвшөөрлийг холбогдох газраас хуулийн дагуу авсан бол зөвшөөрлийн төлбөрт нийт 26,946 доллар төлөх ёстой байсан. Гэтэл шүүхээс оногдуулсан торгууль нь энэ төлбөрийн ердөө 28 хувьтай тэнцэж



байна. Энэ нь бусад хүмүүст энэ мэтчилэн зөвшөөрөлгүйгээр барилга барьж зөвшөөрлийн төлбөрөөс бага хэмжээтэй торгууль төлөх буруу жишиг бий болгох үр дагавартай учраас дээр дурдсан ял шийтгэлийн урьдчилан сэргийлэх зорилгыг алдагдуулж байна гэж үзжээ.

Түүнчлэн Хот төлөвлөлтийн тухай хуулийн 176 дугаар зүйлд заасны дагуу хариуцагчид оногдуулсан торгуулийн хамт нэмэгдэл албадлагын арга хэмжээ авах ёстой байсан. Явган хүний гүүр барих ажил нь тусгай зөвшөөрөл шаардагддаг барилга байгууламжийн нэг төрөл учир хууль бусаар барилга байгууламж барьсан тохиолдолд буруутай этгээд тухайн хэсэг талбайг өмнөх байсан байдалд нь эргүүлж оруулахын тулд албадлагын арга хэмжээ авах шаардлагатай. Күйнсланд мужийн Ял шийтгэлийн тухай хуулийн дагуу албадлагын арга хэмжээ нь тухайн газар нутгийг нөхөн сэргээхэд чиглэсэн ажиллагаа бөгөөд хариуцагчид оногдуулж буй шийтгэлийн нэг хэсэгт тооцогдохгүй.

Дүгнэлт

Явган хүний гүүр барих зөвшөөрлийн төлбөрийг төлөхөөс зайлсхийснээр хариуцагчид ямар нэг ашиг бий болоогүй гэж Магистратын шүүх зөв дүгнэлт хийжээ. Явган хүний гүүрний барилгын ажил бүрэн дуусаагүй байсан бөгөөд барилгын ажлын эхний үе шатанд усны сувгийн урсгал болоод байгаль орчинд нөхөн сэргээлт шаардагдахуйц хэмжээний өөрчлөлтийг үүсгэхгүй (*усны урсгалыг доош элсэн хөвөөгөөр 50 метр хаасан нөхцөлд нөхөн сэргээлт зайлшгүй хийх шаардлагатай нөхцөл үүснэ*) ба талбайн ойр орчмын ургамлын амьдрах нөхцөлд ч мөн нөлөөлөхөөргүй байна.

Иймд яллах талын давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй ба оногдуулсан шийтгэл нь хариуцагчийн үйлдлийн шинж чанарт илтэд тохироогүй гэж үзэх эсхүл нэмэгдэл албадлагын арга хэмжээ аваагүй нь хууль зөрчсөн гэж дүгнэх боломжгүй байна.